



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 8/7296

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын балансад бүртгэлтэй 99,900,000.00 (ерэн есөн сая есөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлэн авч байгаа тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ (Э.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар ( В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



1110205554



### ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалт ад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдах элэгдэл (2022.09.30)	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Бага багтаамжийн автобус	Хьюндай Старекс	04-85 УБР	KMJWA37RA LU118637	2021	99,900,000.00	64,935,000.00	34,965,000.00	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ